



**PAGE** PARTNERSHIP FOR ACTION  
ON GREEN ECONOMY



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН

# ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ



Тогтвортой Хөгжлийн 2030 хөтөлбөрийн  
хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төсөл

2021 он

ТӨСӨЛ



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН

# ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ



Тогтвортой Хөгжлийн 2030 хөтөлбөрийн  
хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төсөл

2021 он



Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн төсвийн шинжилгээ: тайланг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд боловсруулав. Энэхүү тайлан НҮБХХ-ийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

©2021.

Улаанбаатар, Монгол Улс

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн хөгжлийн банк
ААН	Аж ахуйн нэгж байгууллага
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
СЯ	Сангийн яам
ЕХ	Европын холбоо
ЗГСС (GFS)	Засгийн газрын санхүүгийн статистик
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ОУВС	Олон улсын валютын сан
ХАА	Хөдөө аж ахуй
ТХОУХХ (IDDR)	Тогтвортой хөгжил-Олон улсын харилцааны хүрээлэн
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮСХ	Үндэсний статистикийн хороо



## АГУУЛГА

<b>ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ</b>	<b>5</b>
<b>1. Зорилго</b>	<b>9</b>
Тогтвортой хөгжлийн зорилгод чиглэсэн төсөвлөлт, олон улсын туршлага	10
Бодлогын орчин: Тогтвортой хөгжлийн зорилго ба “Алсын хараа-2050”	13
<b>2. Төсвийн шинжилгээ</b>	<b>15</b>
Орлого	19
Урсгал зардал	23
Усны нөөц, гол мөрний менежмент	26
Тусгай хамгаалалттай газрын менежмент	28
Ойжуулалт	30
Ус, цаг уур, орчны шинжилгээ	32
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	34
Аялал жуулчлал	35
Хөрөнгийн зардал	36
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд	39
БОАЖ-ын салбарын бодлогын хэрэгжилт Орон нутгийн түвшинд хэрэгжиж буй байдал	43
<b>Зөвлөмж, дүгнэлт</b>	<b>47</b>
Ашигласан материал	51

## ХҮСНЭГТ

<b>Хүснэгт 1</b> “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	13
<b>Хүснэгт 2</b> БОАЖ-ын салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн төслүүд	40
<b>Хүснэгт 3</b> 2020 оны төсөвт БОАЖ-ын сайдын багцад тусгагдсан гадаадын зээл, тусламжийн төслүүд /сая төгрөг/	41
<b>Хүснэгт 4</b> 2016-2018 онд Орон нутгийн төсвөөс Байгаль орчин хамгааллын чиглэлээр Орон Нутгийн төсвөөс зарцуулсан хэмжээ /сая төгрөг/	44



## ЗУРАГ

<b>Зураг 1</b> Зарим улс орнуудын Байгаль орчны чиглэлээр 2018 онд зарцуулсан төсөв, ДНБ-д харьцуулсан	16
<b>Зураг 2</b> БОАЖ-ын сайдын төсөв 2014-2021 он (днб, улсын төсвийн нийт зардалд харьцуулсан)	16
<b>Зураг 3</b> БОАЖ-ын сайдын төсөв 2015-2021 он (зардлын өсөлт)	17
<b>Зураг 4</b> БОАЖ-ын сайдын төсөв 2014-2021 он (тэрбум төг.)	18
<b>Зураг 5</b> БОАЖ-ын сайдын багцын Төсөвт байгууллагуудын орлого /сая төг./	19
<b>Зураг 6</b> Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 2016-2019 оны хэрэгжилт	21
<b>Зураг 7</b> Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2016-2018 онуудад төвлөрсөн орлого /сая төг/	22
<b>Зураг 8</b> БОАЖСайдын 2016-2020 оны төсвийн зарцуулалт /тэрбум төг./	23
<b>Зураг 9</b> Салбарын 2020 оны төсвийн урсгал зардлыг төлөвлөсөн байдал /сая төг./	25
<b>Зураг 10</b> Усны нөөц, гол мөрний менежментийн чиглэлээр улсын төсвөөс зарцуулж буй төсөв ба тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	26
<b>Зураг 11</b> Усны нөөц, гол мөрний менежментийн чиглэлээр 2020 онд зарцуулах төсвийн санал хянагдсан байдал /сая төг./	27
<b>Зураг 12</b> Тусгай хамгаалалттай газрын менежментийн чиглэлээр улсын төсвөөс зарцуулж буй төсөв ба тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	28
<b>Зураг 13</b> Тусгай хамгаалалттай газрын менежментийн чиглэлээр 2020 онд зарцуулах төсвийн санал хянагдсан байдал /сая төг./	29
<b>Зураг 14</b> Ойжуулалтын зардал ба ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	31
<b>Зураг 15</b> Ойжуулалтын чиглэлээр 2020 онд зарцуулах төсвийн санал хянагдсан байдал /сая төг./	32
<b>Зураг 16</b> Ус цаг уур, орчны шинжилгээ /сая төг./	33
<b>Зураг 17</b> Цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрийн 2020 оны зардлын бүтэц /сая төг./	33
<b>Зураг 18</b> Хүрээлэн буй орчны чиглэлээр зарцуулсан төсөв /сая.төг/	34
<b>Зураг 19</b> Аялал жуулчлалын чиглэлээр зарцуулсан төсөв /сая.төг/ ба гадаад жуулчдын тоо	35
<b>Зураг 20</b> 2015-2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт оруулсан Улсын төсвийн хөрөнгө оруулалт /сая.төг/	36
<b>Зураг 21</b> 2015-2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт оруулсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын бүтэц /сая.төг/	38
<b>Зураг 22</b> Аймаг, нийслэлийн сүүлийн 3 жилд Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр Орон нутгийн төсвөөс зарцуулсан хэмжээ, аймаг, нийслэлийн төсөвт эзлэх хувь	43
<b>Зураг 23</b> Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого, зарцуулалт	45



## 1. ЗОРИЛГО

Байгаль орчин, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн Монгол орны байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төсвийн шинжилгээг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд гүйцэтгэв.

Энэхүү шинжилгээний зорилго Монгол орны байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төсвийн сүүлийн 5 жилийн статистик мэдээлэлд үндэслэн төсвийн хөтөлбөр, арга хэмжээ бүрээр шинжилж, төсвийн хандлагын шинжилгээ хийх, дээрээс доош, доороос дээш чиглэсэн төсөвлөлтийн явцад тулгамдаж буй асуудлуудыг тодруулахад чиглэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төсвийг орлого, урсгал зардал, төсвийн хөрөнгө оруулалт тус бүрээр харьцуулах замаар зардлын хандлагыг тодорхойлох болон тус салбараас улс, орон нутгийн төсөвт төвлөрч буй орлого, хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх талаар зөвлөмжийг гаргав.

Түүнчлэн Тогтвортой хөгжлийн зорилгод (ТХЗ) чиглэсэн төсвийн төлөвлөлтийг бусад орнуудад хэрэгжүүлж буй сайн туршлагаудаас манай улсад хэрэгжүүлэх, ялангуяа байгаль орчин, аялал жуулчлалын салбарын урт ба дунд хугацааны бодлогын зорилтуудыг хангахад нотолгоо-үр дүнд суурилсан төсөвлөлт рүү шилжих урьдач нөхцөлийг танилцуулж байна.



## Тогтвортой хөгжлийн зорилгод чиглэсэн төсөвлөлт, олон улсын туршлага

Тогтвортой хөгжил-Олон улсын харилцааны хүрээлэнгээс “Тогтвортой хөгжлийн зорилгыг үндэсний төсвийн төлөвлөлт хийх явцтай уялдуулах нь” судалгааг 2018 оны 6 дугаар сард боловсруулан гаргажээ. Энэхүү судалгааны дүгнэлтийн дагуу ТХЗ-д чиглэсэн төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлснээр үндсэн 3 чухал ач холбогдолтой байна.



**1. Бодлогын уялдааг илүү тодорхой болгох** ТХЗ-ууд нь урт хугацаанд тогтвортой хөгжилд хөтлөхөд чиглэсэн салбар тус бүрийн тодорхой, харилцан уялдаатай тодорхойлогдсон зорилтууд тул ТХЗ-д чиглэсэн төсвийн төлөвлөлт хийснээр Үндэсний төсвийн төлөвлөлтийг хийх явцад бодлогын арга хэмжээний давхардал багасаж, улмаар төсвийн эх үүсвэр хуваарилах явцад давхардал гарахгүй. Эдгээр ТХЗ олон улсад нэгэн адил нэвтэрч буй тул хил дамнасан бодлогын томоохон арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон улсын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, уялдааг хангахад хялбар байна.



**2. Хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх** ТХЗ-д чиглэсэн төсөв боловсруулахад тухайн арга хэмжээг хэрэгжүүлж хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлдог. Ингэснээр төсвийн хэрэгжилтийн явцад бодлогын арга хэмжээний биелэлтийг жил бүр үнэлэх боломжтой болдог. Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт хийж буй орнуудад үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг чухалчилдаг. Улмаар ТХЗ-д чиглэсэн төсвийн төлөвлөлт нь төсвийн тогтвортой, нэгдмэл байдлыг үнэлэх нэмэлт боломжийг олгодог. Төсвийн хуваарилалт, хүрэх үр дүнг тодорхой гаргадаг тул ТХЗ-д чиглэсэн төсөвлөлтийг төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийг үнэлэх цогц хэрэгсэл байдлаар ашиглаж болох бөгөөд ингэснээр төрийн бус, иргэний нийгмийн байгууллагууд, парламентын зүгээс тавих хяналтыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх тодорхой хувь нэмэр оруулна.



**3. Төсвийг харьцуулах боломж нэмэгдэх** ТХЗ-д чиглэсэн төсөвлөлтийг боловсронгуй байдлаар хэрэгжүүлснээр улсын төсвийг бусад оронтой харилцан адил үзүүлэлтүүдээр харьцуулах боломжийг олгож дэлхийн ТХЗ-ын хэрэгжилтэд хувь нэмэр оруулна. Түүнчлэн бусад орны эрдэмтэн, судлаачдад тодорхой бүтэцтэй, цэгцтэй, бодит мэдээлэл хүрч, гадаад зах зээлд улсын төсөв, санхүүгийн мэдээлэл бодитой хүрнэ.

Тус судалгаанд дурдсанаар Европ тивийн нийт 23 оронд үндэсний бодлогын баримт бичгүүдийг Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөртэй уялдуулан шинэчилж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн яамдаас бодлогын дэмжлэг үзүүлж байна. Мөн түүвэр судалгаанд орсон 7-8 улс орон ТХЗ-д чиглэсэн төсвийн төлөвлөлтийн аргачлалыг тухайн улсынхаа төсвийн хэрэгжилтийг үнэлэх хэрэгсэл байдлаар ашиглаж эхэлсэн байна.

Европын Тогтвортой хөгжлийн нийгэмлэгээс боловсруулсан “Европ тивийн орнуудын Тогтвортой хөгжлийн зорилгод чиглэсэн төсөвлөлт: Туршлага, сорилт, хэрэгцээ шаардлага” (2019) судалгаанд ТХЗ-д чиглэсэн төсөвлөлтөд шилжих үйл явц нь тодорхой үе шатуудыг дамжин хэрэгжих, хугацаа шаардсан үйл явц бөгөөд улс, орнууд харилцан адилгүй стратеги боловсруулан алхам алхмаар шилжиж байгааг дурджээ.

Тухайн улс орны үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтууд, тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан боловсруулсан тогтвортой хөгжилд хөтлөх урт хугацааны стратеги боловсруулах нь ТХЗ-д чиглэсэн, нотолгоо-үр дүнд суурилсан төсөвлөлт рүү амжилттай шилжих эхний алхам болохыг тодотгожээ.

Аливаа улсын төсөв боловсруулах үйл явцад ТХЗ-д чиглэсэн төсөвлөлтийг нэвтрүүлэхийн тулд улс орны онцлог, эдийн засгийн гол хөдөлгөгч хүчин зүйлс, нөхцөл байдлаас хамаарч зарим шаардлагатай тохируулгыг хийх шаардлагатай байдаг. Түүнээс гадна Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын оролцоо, төрийн бус байгууллагууд, төрийн аудит, хяналт шалгалтын байгууллагуудын идэвх, санаачилга, цаашлаад улс төрийн дэмжлэг хэрэгтэй болдог байна.

Энэхүү судалгаанд Европын Тогтвортой хөгжлийн нийгэмлэгийн судалгаанд Европ тивийн нийт 13 оронд санал асуулга явуулж, ТХЗ-д чиглэсэн төсөвлөлтийн явц байдлыг дүгнэсэн байна. Тухайлбал Австри Улс өмнө хэрэгжүүлж байсан Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн аргачлалыг тодотгож, тэр дундаа гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг ТХЗ-ын хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдтэй нийцүүлэх замаар хэрэгжүүлж байгаа бол Финлянд Улс тогтвортой хөгжлийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бие даасан системтэй болж Засгийн газраас Парламентад жил бүр танилцуулдаг тайланд тогтвортой хөгжилд хүрэх хууль эрх зүйн болон төсвийн асуудлуудыг тусгадаг болжээ. Мөн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тогтвортой хөгжлийн зарчмууд, гол зорилтуудыг оруулж Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн төсөл боловсруулах процесст тусгадаг байх механизм бүрдүүлсэн байна. Финляндын 2019 оны төсвийн танилцуулгад тогтвортой хөгжилд хөтлөх салбар дундын уялдаа холбоо, тохируулгууд тодорхой томъёолж, гол нэр төрлийн зардлын зүйлүүд дээр шаардлагатай шинэчлэлийг нэвтрүүлжээ.

ХБНГУ-ын хувьд Холбооны Канцлер тэргүүлэн Үндэсний тогтвортой хөгжлийн стратегийг мөрдөн ажилладаг. Энэхүү стратеги нь Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн суурь болдог. Холбооны Засгийн газрын яамдууд тус бүр ТХЗ-ын хэрэгжилт, явц, ахицын талаар бие даан үнэлгээ хийж, хэрэгжилтийг дүгнэдэг байна.

Исланд Улсад Санхүү, эдийн засгийн яам Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг хөтлөх мэдээллийн системээр дамжуулан хэрэгжилтийг бүртгэх замаар зорилтот үр дүнг тайлагнадаг байна. Нэгдсэн мэдээллийн систем ашигладаг тул Парламент, Засгийн газрын төсвийн зарцуулалт бүр ТХЗ-ын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй автоматаар холбогдож, төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлдэг. Мөн жил бүрийн төсөв боловсруулахад яам тус бүр ТХЗ-ын үр дүнг дүгнэж, дараагийн төсвийн жилийн зорилтуудыг тодорхой тусгадаг байна.

“Европ тивийн орнуудын Тогтвортой хөгжлийн зорилгод чиглэсэн төсөвлөлт: Туршлага, сорилт, хэрэгцээ шаардлага” (2019) судалгаанаас үзэхэд ихэнх орон ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд нэмэлт төсөв хуваарилахаас илүүтэй хуваарилагдсан төсөвт багтаан Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн зорилгуудад үе шаттайгаар чиглэж, хэрэгжилтийг Засгийн газрын бүрэлдэхүүн, яамдад даалгаж байна. Судалгаанд хамрагдсан орнуудын үндэсний хөгжлийн бодлогын баримтуудад тусгагдсан урт хугацааны стратегиуд нь ТХЗ 2030-тай уялдаж байна.

Монгол Улсын хувьд 2020 оны 5 дугаар сард батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь үндэсний хөгжлийн зорилтуудыг урт хугацаанд хангахаас гадна дэлхийн Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт тусгагдсан зорилтуудтай нягт уялдаж байгаа тул ТХЗ-д чиглэсэн, нотолгоо-үр дүнд суурилсан төсөвлөлт рүү шилжих урьдач нөхцөлийг бүрдүүлэх гол хүчин зүйл болж байна.



## Бодлогын орчин: Тогтвортой хөгжлийн зорилго ба “Алсын Хараа-2050”

Тогтвортой хөгжлийн зорилго Монгол Улсын байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлоготой хэрхэн уялдаж байгаа байдлыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тодорхойлсон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудалд хамаарагдах бодлогын зорилго, шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзлээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогод тусгагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах зорилт, шалгуур үзүүлэлтүүд дээрх ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй хэрхэн уялдаж буйг доорх Хүснэгт 1-д харуулав. Байгаль орчин, аялал жуулчлалд хамааралтай ТХЗ 6, 8, 11, 12, 13, 15 зорилгуудын 35 шалгуур үзүүлэлтүүдээс 10 шалгуур үзүүлэлт нь “Алсын хараа-2050”-ын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдаж байна.

Хүснэгт 1. “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Суурь	Хүрэх түвшин			ТХЗ-ын шалгуур үзүүлэлт	
			2025	2030	2050		
<b>Дөрөв. Эдийн засаг</b>							
1	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	сая хүн	0.6	1	2	6	8.9.1. ДНБ болон түүний өсөлтөд аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь
<b>Зургаа. Ногоон хөгжил</b>							
2	Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт (EPI – Environmental Performance Index)	оноо	57.2	58	59	61+	
3	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	20.1	27	30	35	15.1.2. Эх газрын болон цэнгэг усны биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг хамгаалалтад авсан байдал, экосистемийн төрлөөр – Тусгай газар нутгийн эзлэх хувь
4	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	48.3	55	60	75	15.1.2. Эх газрын болон цэнгэг усны биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг хамгаалалтад авсан байдал, экосистемийн төрлөөр - Хамгаалалтад авсан усны урсац бүрэлдэх эхийн эзлэх хувь
5	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	7.9	8.7	9	10.5	15.1.1. Ойгоор бүрхэгдсэн газрын нийт газар нутагт эзлэх хувь

6	Газрын доройтлын хувь	мкг/ м3	22.9	22.9	22.9	15.3.1. Доройтсон газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	
7	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	хувь	14	23	30	50	
	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	82.5	85	87	90	
	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	69	70	75	90	
8	Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь	хувь	суурь	12.3	22	-	13.2.1 Хүнсний үйлдвэрлэлд саад болохгүйгээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг бий болгох, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх талаар нэгдсэн бодлого, стратеги, төлөвлөгөөг бий болгон хэрэгжүүлж байгаагаа мэдээлж байгаа эсэх
9	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	7.6	27	40	50	12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын үндэсний түвшин, дахин боловсруулсан материал, тонноор
10	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	25.6	52	64	90	11.6.1 Хот суурин газарт тогтмол цуглуулдаг хатуу хог хаягдал, түүнээс хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь, хотоор
<b>Ес. Улаанбаатар ба дагуул хот</b>							
11	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/ м3	64	40	25	-	11.6.2 Хотын агаар дахь нарийн болон том ширхэглэгт тоосонцрын (өөрөөр хэлбэл, PM 2.5 болон PM 10) жилийн дундаж хэмжээ (хүн амд харьцуулсан)
12	Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/ м3	141	88	50	-	11.6.2 Хотын агаар дахь нарийн болон том ширхэглэгт тоосонцрын (өөрөөр хэлбэл, PM 2.5 болон PM 10) жилийн дундаж хэмжээ (хүн амд харьцуулсан)

Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/15406?lawid=15406>



## 2. ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ

Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) Засгийн газрын санхүүгийн статистикийн үйл ажиллагааны чиглэлээр ангилан тодорхойлсноор Азийн зарим орон, хил залгаа хөршүүд болон хуучин Зөвлөлт Холбоот Орос Улсын харьяанд байсан зарим орны байгаль орчны чиглэлээр зарцуулж буй төсвийг харьцуулан үзэхэд Монгол улс бусад улс орны жишгээс бага төсвийг энэ чиглэлд зарцуулж байна.


Улс орон бүрийн газар нутаг, уур амьсгалын онцлог, газарзүйн бүс бүслүүр, эдийн засгийн чадавх харилцан адилгүй боловч байгаль орчны чиглэлээр зарцуулж буй төсвийн хэмжээг ДНБ-д харьцуулан харснаар тухайн улсын байгаль орчныг хамгаалах санаачилга, оролцоог харж болно.

**Япон, Хонконг** зэрэг өндөр хөгжилтэй орнууд байгаль хамгаалал болон энэ талын судалгаа шинжилгээнд олон талын ач холбогдол өгч ДНБ-нийх 1.4-2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг үндэсний төсвөөс зарцуулж байгаа бол **Казахстан, Украин** зэрэг орон 2018 онд энэ чиглэлээр ДНБ-ний 0.5 орчим хувьтай тэнцэх хэмжээний зардлыг хуваарилан зарцуулсан байна. Газар нутаг том, байгалийн олон бүслүүр дамжин оршдог хөрш **ОХУ-д** энэ үзүүлэлт 0.29 хувь байна.






Зураг 1. Зарим улс орнуудын Байгаль орчны чиглэлээр 2018 онд зарцуулсан төсөв, ДНБ-д харьцуулсан



Эх сурвалж: IMF, Government Finance Statistics (GFS), Expenditure by Function of Government (COFOG), <https://data.imf.org>

2018 оны байдлаар Монгол Улс ДНБ-ний 0.57 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг хүрээлэн буй орчин, байгаль хамгааллын чиглэлээр зарж байна. Үүнд, тусгай хамгаалалттай газар нутгийн Байгаль хамгаалал, агаарын бохирдолтой тэмцэх чиглэлд төсвийн санхүүжилтийг түлхүү хуваарилж байна. Мөн байгаль хамгааллын бусад зардлууд буюу энэ чиглэлийн байгууллагуудын захиргааны зардалд ДНБ-ний 0.12 хувийг зарцуулж байна. Харин Япон, Хонконг зэрэг орны хувьд энэ чиглэлийн байгууллагуудын захиргааны зардал харьцангуй бага байна.


Зураг 2. БОАЖ-ын сайдын төсөв 2014-2021 он (ДНБ, улсын төсвийн нийт зардалд харьцуулсан)



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, БОАЖА Санхүүгийн хэлтэс

2016 оны төсвийн жилээс БОАЖ-ын сайдын багцын зардлын Улсын төсвийн нийт зардлын хэмжээнд эзлэх хувь жил бүр тогтвортой өсөж 2021 онд 1.54 хувьд хүрсэн бол ДНБ-д харьцуулсан хувь 2021 онд өмнөх оноос 0.02 хувиар буурч 0.39 хувьд хүрсэн байна. Энэ нь КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр төсвийн зардал буурсан боловч энэ салбарын төсвийн зардал буураагүй болох нь харагдаж байна. Хэдийгээр цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт саарч төсвийн нийт зардал буурах хандлагатай боловч энэ салбарын төсвийн зардлын улсын төсвийн нийт зардалд эзлэх хувь тогтмол өсөх хандлагатай байна.

Зураг 3. БОАЖ-ын сайдын төсөв 2015-2021 он (зардлын өсөлт)



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, БОАЖА Санхүүгийн хэлтэс

Улсын төсвийн нийт зардал өсөхийг хэрээр энэ салбарын нийт зардал 2016 оноос 2020 оны дунд хүртэл харьцангуй өсөлттэй, төсвийн зардал тэлж байв. Ялангуяа, 2019 оны БОАЖ-ын сайдын багц 73.6 хувиар өсжээ. Харин цар тахлын нөлөөллөөр эдийн засгийн өсөлт саарсантай холбогдуулан Засгийн газрын зүгээс төсвийн хумих бодлогыг хэрэгжүүлж төсвийн зардлыг бууруулах чиглэл баримтлан 2020 оны сүүлийн улиралд 16 хувиар, 2021 оны төсвийн жилд 23.2 хувиар бууруулсан бол БОАЖ-ын сайдын багцын төсөв мөн 6-10 орчим хувиар буурсан байна.

Салбарын яамны төсвийн зардлын хэмжээ нь Засгийн газраас баримталж буй төсвийн бодлого, БОАЖА-ны бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл, төсвийн хэлэлцүүлгийн явцаас хамаардаг. Байгаль орчныг хамгаалах асуудлыг салбаруудын бодлогод амжилттай суулгаж, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2016 онд, Ногоон хөгжлийн бодлогыг 2014 онд тус тус баталснаар энэ чиглэлийн бодлогын зорилтууд тодорхой болж хэрэгжүүлэх төсөв, санхүүжилт нэмэгдэж, нөхцөл, боломж бүрдсэн байна.

2016 оны төсвийн жилээс БОАЖ-ын сайдын багцын зардлын Улсын төсвийн нийт зардлын хэмжээнд эзлэх хувь жил бүр тогтвортой өсөж 2021 онд 1.54 хувьд хүрсэн бол ДНБ-д харьцуулсан хувь 2021 онд өмнөх оноос 0.02 хувиар буурч 0.39 хувьд хүрсэн байна. Энэ нь КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр төсвийн зардал буурсан боловч энэ салбарын төсвийн зардал буураагүй болох нь харагдаж байна. Хэдийгээр цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт саарч төсвийн нийт зардал буурах хандлагатай боловч энэ салбарын төсвийн зардлын улсын төсвийн нийт зардалд эзлэх хувь тогтмол өсөх хандлагатай байна.

Зураг 4. БОАЖ-ын сайдын төсөв 2014-2021 он (тэрбум төг.)



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, БОАЖЯ Санхүүгийн хэлтэс


2014 оноос 2016 оныг хүртэл Засгийн газраас баримталсан төсвийн бодлого, чиглэлийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын нийт зардлыг бууруулж, хэмнэлтийн горимд ажиллах болсонтой холбогдуулан салбарын төсвийг 13.6 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Харин 2017-2020 оны дунд хүртэл эдийн засгийн өсөлтөөс улбаатай энэ салбарын төсвийн санхүүжилт тогтвортой нэмэгдсэн байна. Ялангуяа, сүүлийн 4 жилд энэ салбарт төсвийн хөрөнгө оруулалтын зардал жил бүр нэмэгдэж байна. Харин 2020 оны сүүлийн хагасаас цар тахлын нөлөөллөөс үүдэлтэй төсвийн зардлын хэмжээг бууруулах, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулсан байна.

## Орлого

### Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого

Энэ салбарын босоо тогтолцоотой байгууллагуудын үйл ажиллагааны орлого Улсын төсөвт төвлөрдөг. Тусгай хамгаалалттай газрын захиргаад хариуцсан газар нутагт нэвтрэх хураамжийн орлого, сав газрын захиргаад Усны дүгнэлт гаргасны үйлчилгээний хураамжийн орлого зэргийг төвлөрүүлдэг бол Байгаль орчны шинжилгээний төв лаборатори, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв зэрэг байгууллага үйлчилгээний хураамжийн орлого бүрдүүлдэг. Эдгээр үйл ажиллагааны орлогуудыг тухайн байгууллагын тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр болгон ашигладаг. Иймээс байгууллагын урсгал зардлыг мөн нэмэгдүүлдэг тул зардалтай уялдуулан төлөвлөдөг.

Зураг 5. БОАЖ-ын сайдын багцын Төсөвт байгууллагуудын орлого /сая төг./



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, БОАЖЯ Санхүүгийн хэлтэс

2020 оны төсвийн төсөлд харьяа байгууллагуудаас 388.5 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэх санал ирүүлсэн боловч хэт өндөр орлогын төлөвлөгөө гаргах, үүнтэй уялдуулан урсгал зардал нэмэгдүүлэхгүй байх шаардлагад үндэслэн 2019 оны түвшинд төлөвлөсөн байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөх нэг удаагийн ажил үйлчилгээний хөлсний хэмжээг Байгаль орчны сайдын 2001 оны 117 дугаар тушаалаар батлагдсан "Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс төлөх журам"-аар зохицуулж Гадаадын иргэнээс 3,000 төгрөг, дотоодын иргэнээс 300 төгрөгийн хураамж авч байна.

2013 оны 5 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж болон үзүүлэх ажил үйлчилгээний хөлс төлөх журам, Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж болон үзүүлэх ажил

үйлчилгээний хөлсний тасалбарын загвар, Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэхэд төлөх хураамж болон ажил үйлчилгээний хөлсний хэмжээг тус тус шинэчлэн боловсруулсан боловч тус шийдвэр нь “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд гаргана” гэсэн шаардлагыг хангаагүй, хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөөгүй байна. Тус журмын төсөлд тусгаснаар, гадаадын иргэн тусгай хамгаалалттай нутагт нэвтрэхэд 5,000 төгрөгийн хураамж төлөхөөр заасан байв.

Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс төлөх журмын төсөл боловсруулахдаа 29 хамгаалалтын захиргаа, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг 22 аж ахуйн нэгж, байгууллага, 141 байгаль хамгаалагч, 1411 дотоодын жуулчин, 643 гадаадын жуулчдыг хамарсан судалгаа явуулжээ. Үр дүнг нэгтгэн, санал боловсруулж Тусгай хамгаалалттай газар нутгийн төв, хангай, говийн бүсийн 17 хамгаалалтын захиргаа, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд, ТББ, Олон улсын байгууллагын төлөөлөл оролцсон таван удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, гаргасан саналуудыг тусгасан байна.


Эдийн засгийн өсөлт, инфляц, төгрөгийн ханшийн өөрчлөлт зэргийг харгалзан байгаль орчны салбарын байгууллагын үйлчилгээний хураамжийн хэмжээг дахин авч үзэх шаардлагатай байна. Сав газрын захиргаадаас орон нутгийн ААН-үүдэд гаргаж буй дүгнэлтийн хураамж, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйлчилгээний төлбөрийг нэмэгдүүлэх талаар харьцуулсан судалгаа хийж, үнэ тарифыг эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн нэмэгдүүлэх, салбар байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөх шаардлагатай.



## Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого

Байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа эдийн засгийн бусад үйл ажиллагааны хохирлыг бууруулах, эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх, байгаль орчны бохирдлыг багасгах хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулах хуулийн зохицуулалттай. Төсвийн төвлөрлийг сааруулах нэгдсэн зарчмын хүрээнд боловсруулагдсан Төсвийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг хураан сум, дүүргийн төсөвт тушаана. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш тус хуулийн хүрээнд төвлөрүүлсэн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээхэд зарцуулж буй хөрөнгийн хэмжээ хангалтгүй, хуулийн хэрэгжилт 2016-2019 онд дунджаар 37.1 хувьтай байна.

Зураг 6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 2016-2019 оны хэрэгжилт




Эх сурвалж: БОАЖА, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Тус хуулийн 2016-2018 оны хэрэгжилтээс харахад хуулийн талаарх сурталчилгаа болон тухайн Орон нутгийн удирдлагын арга барил, ажлын зохион байгуулалтаас хамаарч хуулийн хэрэгжилтэд жил ирэх тутам ахиц гарч байна. Энэхүү хуулийн хүрээнд 2016-2018 оны хооронд нийт 162.2 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөн бол төвлөрүүлэх орлогын тоон хэмжээ харьцангуй бага Архангай, Говьсүмбэр аймгуудад хуулийн хэрэгжилт сайн байна.

Хуулийн хэрэгжилтийг байгалийн нөөцийн нэр төрлөөр судлан үзвэл Ус, рашааны нөөц ашигласны төлбөр болон Газрын нөөц ашигласны төлбөрүүд ихэнх хувийг эзэлж, томоохон уул уурхай, үйлдвэрлэл эрхэлдэг аймгуудад харьцангуй их орлого төвлөрч байна. Иймд томоохон ус ашиглагч байгууллага, уул уурхайн үйлдвэрлэл явагддаг аймгийн БОАЖ-ын газруудын мэргэжилтэн, аймаг, сумын ИТХ-ын гишүүдэд хуулийн талаар сурталчлах, байгалийн нөөц ашиглалтаас төвлөрөх орлогын бүрдүүлэлтийн хуульд заасан хэмжээнд бүрэн төвлөрүүлэх, мөн энэхүү орлогоос бүрдсэн эх үүсвэрийг байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр зохистой зарцуулах чиглэлээр мэргэжлийн сургалтыг холбогдох байгууллагууд хамтран зохион байгуулж орон нутгийн хариуцсан байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна.

Зураг 7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2016-2018 онуудад төвлөрсөн орлого /сая төг/



Эх сурвалж: БОАЖЯ, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

### Ус бохирдуулсны төлбөрийн орлого.


Хаягдал усан дахь бохирдлыг үе шаттай бууруулж, улмаар байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөг багасгах, усыг зүй зохистой дахин ашиглах, үүнд чиглэсэн техник технологийг нэвтрүүлэх, усны зүй зохистой хэрэглээг нэмэгдүүлэх, хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг бууруулах зорилгоор Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой

болгож, хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих эрхийг сав газрын захиргаанд олгохоор шинээр тусгасан нь тус хууль хэрэгжих үндсэн суурь нөхцөлийг бий болсон.

Уг хуулийн хэрэгжилтийн хүрээнд улсын хэмжээнд 2020 оны төсөвт Ус бохирдуулсны төлбөрөөс 1.0 тэрбум, Нөхөн төлбөрөөс 2.8 тэрбум, нийт 3.9 тэрбум төгрөг төвлөрүүлэх төсөөлөлтэй байна. Усны төлбөрийн орлогыг усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50-аас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулахаар хуульчилсан. Энэхүү хууль эрх зүйн шинэ зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах нь цэвэрлэх байгууламжуудыг үйл ажиллагааг дэмжих цаашлаад хөрс, орчны бохирдлыг бууруулахад шууд ач холбогдолтой.

### Урсгал зардал

Зураг 8. БОАЖСайдын 2016-2020 оны төсвийн зарцуулалт /тэрбум төг./



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ, ЗГҮАХ-ийн тайлан 2019

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн зарцуулалт сүүлийн 5 жилд үе шаттай нэмэгдэж, улсын төсвийн 1.62% байхаар 2020 оны төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан байна. Харин сайдын төсвийн 81.2% (сүүлийн 5 жилийн дундаж)-ийг урсгал зардал эзэлж байгаа нь энэ салбарт хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээ харьцангуй бага тусгаж, үйл ажиллагааны зардал тогтмол өсөж байгааг харуулж байна. 2016 оноос өнөөг хүртэл тус салбарын зардлын хандлага өсөх хандлагатай байгаа бөгөөд 2020 онд нийт

зардлыг 96.6 хувиар буюу 86.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээс дийлэнх хэсгийг буюу 73.3 тэрбум төгрөгийн урсгал зардлыг нэмэгдүүлж төлөвлөжээ. Урсгал зардлын энэхүү өсөлт нь эдийн засгийн өсөлт, нөхцөл байдал, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэр, бүтцийн өөрчлөлт, үйл ажиллагааны цар хүрээ өргөжсөн зэрэг олон шалтгаантай.

БОАЖЯ-ны төсвийн урсгал зардлыг үйл ажиллагааны чиглэлээр ялган шинжилж үзвэл Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэл зарцуулж буй урсгал зардлын хэмжээ сайдын багцын төсөвт дийлэнх хувийг эзэлж иржээ. Энэ нь Төсвийн төвлөрүүлэн захирагч Ус, цаг, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны онцлог, орон нутагт ажилладаг салбаруудын цар хүрээнээс хамаарч байна. Засгийн газраас дэвшүүлсэн Агаар, орчны бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд 2019 оноос агаарын бохирдолтой тэмцэх арга хэмжээнд урсгал зардлыг түлхүү хуваарилж эхэлсэн. 2020 оны төсвийн




НҮБХХ, СЯ, БОАЖЯ хамтран 2019 оноос хамтран хэрэгжүүлж байгаа Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төслийн дэмжлэгтэйгээр “Тогтвортой хөгжлийн зорилгыг төсөвтэй уялдуулсан нэмэлт төсвийн туршилтын маягт”-ын дагуу боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны төсөвт нэмэгдүүлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, хамгааллын менежментийг сайжруулах (4 арга хэмжээнд 3.903.1 сая төгрөг), Газрын доройтлыг бууруулах, доройтсон, эвдэрсэн, цөлжсөн газарт нөхөн сэргээлт хийх, урьдчилан сэргийлэх (5 арга хэмжээнд 1,267.0 сая төгрөг) нийт 5,170.1 сая төгрөгийн нэмэлт төсвөөр хамгаалалтын захиргаадын төсөв, байгаль хамгаалагчийн орон тоог нэмэгдүүлснээр хүн хүчний хангамж сайжирч, эргүүл хяналтыг тогтмолжуулсан, зөрчил гарахаас сэргийлэх, зөрчлийн тоо буурсан, иргэдийн мэдлэг ойлголт нэмэгдсэн, хашаалж хамгаалсан талбайд ховор ургамал, мод ургаж эхэлсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн байна.



төслийг боловсруулахад Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос орон тоо нэмэгдүүлэх, урсгал санхүүжилтийг өсгөх саналыг хүргүүлж энэ чиглэлээр УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг үндэслэн суурь төсвийг тооцоолж, улмаар 2019 онтой харьцуулахад 50.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ.

2020 оны төсвийн төслийг боловсруулах явцад салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналын нэгтгэлээс харахад байгууллагуудаас ирүүлж буй саналын 40% орчим хувийг орон тоо нэмэгдүүлэх, 21% хувь нь урсгал засвар хийх, мөн 8.4%-ийг тавилга, тоног төхөөрөмж худалдан авах санал эзэлж байна. 2020 оны төсвийн төсөлд харьяа байгууллагуудаас 269.2 тэрбум төгрөгийн төсвийн саналыг ТЭЗ-д хүргүүлсэн бол БОАЖЯ-ны зүгээс хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах бусад арга хэмжээний зардлыг нэмэгдүүлж нийт 381.0 тэрбум төгрөгийн төсвийн саналыг хүргүүлсэн бол Сангийн яамнаас энэ салбарын суурь төсвийг 2020 онд 114.4 тэрбум төгрөг байхаар тооцжээ.

Зураг 9. Салбарын 2020 оны төсвийн урсгал зардлыг төлөвлөсөн байдал /сая төг./



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг төлөвлөн харгалзах төсвийн төслийг боловсруулсан боловч Засгийн газрын зүгээс эдийн засгийн төлөв байдал, төсвийн орлогын бүрдүүлэлт зэргийг харгалзан төсвийн саналыг бууруулж 2020 онд тус ТЭЗ-ийн төсвийг 176.2 тэрбум төгрөг байхаар баталжээ. 2020 оны 1 дүгээр сарын байдлаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 121, улсын тусгай хамгаалалт, сав газрын захиргаадад 966, цаг уур, орчны шинжилгээний газарт 1835, нийт 2,922 албан хаагч ажиллаж байна.

Салбарын төсвийн шууд захирагч (төсвийн байгууллага), төсвийн төвлөрүүлэн захирагч (агентлаг), төсвийн ерөнхийлөн захирагчид (яам) Төсвийн тухай хуульд тусгагдсан төсвийн зарчмуудыг мөрдөн УИХ-аас гарсан шийдвэрүүд, ЗГ-ын мөрийн хөтөлбөрт туссан зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн зорилтын хүрээнд төсвийн санал боловсруулдаг.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хувьд 2019-2020 оны төсвийн жилд агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг чухалчлан харьцангуй илүү санхүүгийн хөрөнгө зарцуулсан. Харин цаашид салбарын эрхлэх асуудлуудын хүрээнд бусад салбарт төсвийн хүртээмжийг тэнцвэржүүлэх, ач холбогдлыг харгалзан жигд хуваарилах, салбарын тэргүүлэх чиглэлийг харгалзан байгаль орчны бусад салбаруудыг орхигдуулахгүйгээр төсвийн дахин хуваарилалт хийх ажлыг Сангийн яамны оролцоотой эхлүүлэх шаардлагатай байна.



### Усны нөөц, гол мөрний менежмент

Монгол орны усны хэрэглээний 90 хувь нийт усны нөөцийн 2 хувь болох газрын доорх усны нөөцөөс хангагддаг. Цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 48.4 хувь, ойн сан бүхий газрын 39.3 хувийг Улсын тусгай хамгаалалтад авсан байна. "Ус" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол орны усны нөөцийг хамгаалан түүний бүрэлдэн тогтох, цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх бүхий л боломжийг хангах, нутаг дэвсгэрийн хэмжээнд усны нөөц, чанарын хяналт-шинжилгээний байнгын, тасралтгүй, шинэ дэвшилтэт технологид суурилсан сүлжээ байгуулан ажиллуулж мэдээлэл, удирдлагын шуурхай байдлыг хангах чиглэлээр БОАЖЯ-аас 2016-2020 оны усны нөөц, гол мөрний менежментийн чиглэлээр багц арга хэмжээ хэрэгжүүлж, улмаар тус салбарт зарцуулах төсвийн хэмжээ жил бүр нэмэгдэж иржээ.

Зураг 10. Усны нөөц, гол мөрний менежментийн чиглэлээр улсын төсвөөс зарцуулж буй төсөв ба тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь




Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ, ЗГҮАХ-ийн тайлан 2019

2015-2018 оны хооронд цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах өргөн цар хүрээг хамраагүй, энэ талаар суурь судалгаа хангалтгүй байж үүнийг дагаад улсын төсвөөс энэ салбарт хуваарилагдах хөрөнгийн хэмжээ мөн тогтвортой, өсөлт инфляцын түвшинд байж ирсэн. Харин 2019 оноос үндэсний хөтөлбөрийн үр дүн гарч, улсын хамгаалалтад авах талбайн хэмжээ нэмэгдсэнтэй уялдаж усны нөөц, гол мөрний менежментийг бэхжүүлэх чиглэлийн төсөв 2019 онд 11.3% хувиар нэмэгдэж, 2020 онд 48.4 хувиар нэмэгдсэн байна. Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хэмнэх, хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх, үерийн аюулаас сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үүнд чиглэсэн аливаа үйл ажиллагаа, санал санаачилгыг дэмжихэд зориулж төсөв нэмэгдүүлэх санал хүргүүлж улмаар 2020 оны төсөв 1.6 тэрбум төгрөгийн урсгал зардлыг нэмж тусгасан байна.

Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх талбайн эзлэх хэмжээ нэмэгдэхийн хэрээр цалин, томилолт, тээвэр шатахууны зардал нэмэгдэж байна.



Зураг 11. Усны нөөц, гол мөрний менежментийн чиглэлээр 2020 онд зарцуулах төсвийн санал хянагдсан байдал /сая төг./



Эх сурвалж: БОАЖЯ

Усны нөөц, гол мөрний менежментийг хэрэгжүүлж, голын эх болон булаг, шандуудын эх үүсвэрийг хамгаалах ажлын ихэнх хэсэг газарзүйн хувьд алслагдмал орон нутагт гүйцэтгэгдэг. Энэ үйл ажиллагааг өргөтгөхийн тул БОАЖЯ-ны харьяа, босоо тогтолцоотой сав газрын захиргааны зүгээс 2020 оны төсвийн төсөлд орон тоо нэмэгдүүлэх тодорхой саналуудыг хүргүүлсэн байна. Харин БОАЖЯ-ны зүгээс бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан усны сав газруудын мужлалыг шинэчлэх, ус бүрэлдэх мужлалд үндэслэн сав газруудын бүтцийг өөрчлөх, тусгай хамгаалалттай газар нутаг нэмэгдэхийн хэрээр усны нөөцийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах зардал, орон тооны саналыг хүргүүлсэн байна.

Харьяа байгууллагууд болон Төсвийн ерөнхийлөн захирагч БОАЖЯ-ны 2020 оны төсвийн төсөлд өгсөн саналаас харахад Усны нөөц, гол мөрний менежментийг хэрэгжүүлэх, усны нөөцийг хамгаалахад орон тоог нэмэгдүүлж цалингийн санг нэмэгдүүлэх, тогтмол эргүүл хамгаалалтыг хийх томиллотын зардлуудыг нэмэгдүүлэх саналууд дийлэнх хувийг эзэлж байна.

Экосистемийн ачаалал ихсэж, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэм зөрчигдөж, усны нөөц бохирдон хомсдож, үер усны гамшгийн давтамж нэмэгдэж байгааг БОАЖЯ-аас судалгаагаар тогтоосон байна. Мөн улсын хэмжээнд ус ашиглалт, усны хэрэглээнд хяналт тавих боломж дутмаг байна.

Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх бүхий газрыг хамгаалах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулах чиглэлээр “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт болон бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан тодорхой арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлэх, түүнд шаардагдах төсвийг улсын төсөв болон бусад төсвийн эх үүсвэрүүдийг дайчлан нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### Тусгай хамгаалалттай газрын менежмент

Зураг 12. Тусгай хамгаалалттай газрын менежментийн чиглэлээр улсын төсвөөс зарцуулж буй төсөв ба тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ, ЗГҮАХ-ийн тайлан 2019


Тусгай хамгаалалттай газрын менежмент, байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцвэрийг хадгалах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах талаар гаргасан Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ, 2010), Ногоон хөгжлийн бодлого (УИХ, 2014) зэрэг бодлогын бичиг баримтуудыг хэрэгжүүлэх хүрээнд сүүлийн 5 жилд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ тогтмол өсөж байна. Улмаар улсын төсвөөс тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн чиглэлээр зарцуулах хөрөнгийн хэмжээ мөн үе шаттай нэмэгдсээр иржээ. 2018 онд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2.26 хувиар нэмэгдсэнтэй уялдан 731.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2020 оны төсвийн төслийг боловсруулах явцад БОАЖЯ-ны зүгээс НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Тогтвортой хөгжлийн зорилгыг төсөвтэй уялдуулах, хөтөлбөр-үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг энэ салбарт хэрэгжүүлэхээр “Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, хамгааллын менежментийг сайжруулах” төсвийн хөтөлбөрийг эхлүүлж,

нэмэлт төсвийн маягт боловсруулан, улмаар улсын төсвийн санхүүжилт нийт 3.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

УИХ-ын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийн 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ” гэж тодорхойлсны дагуу БОАЖЯ-аас бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж, УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн тогтоолоор 6 аймгийн 14 сумын нутаг дэвсгэрийг хамарсан нийт 9 газар нутгийг шинээр болон өргөтгөлөөр улсын тусгай хамгаалалтад авсан. 2020 оны 8 дугаар сарын байдлаар Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 20.94 хувь байна.

Зураг 13. Тусгай хамгаалалттай газрын менежментийн чиглэлээр 2020 онд зарцуулах төсвийн санал хянагдсан байдал /сая төг./



Эх сурвалж: БОАЖЯ

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг хэрэгжүүлэх, хамгааллын сүлжээг өргөтгөх чиглэлээр улсын төсвөөс зарцуулж буй зарцуулалтыг зардлыг бүтцээр харьцуулан үзвэл нийт зардлын 51.2 хувийг цалин, түүнтэй адилтгах даатгал, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулж байна. 2020 оны төсвийн төслийг боловсруулахад Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаадаас ирүүлсэн санал дээр Гэрээт байгаль хамгаалагчдын зардал,

тусгай хамгаалалтын сүлжээг өргөтгөх, томилолт, түлш, шатахууны зардлыг нэмэгдүүлж тооцжээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаад энэхүү нэмэлт төсвийг 2020 оны төсвийг боловсруулахад тодорхойлсон хөтөлбөр-үр дүнд суурилсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан байдлаар хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах үүрэгтэй. Цаашид тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагыг оновчтой, урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхийн тулд төсвийн урсгал болон хөрөнгийн зардлын хэмжээг тогтмол нэмэгдүүлэх шаардлагатай.

### Ойжуулалт

Манай орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ 12,452.0 мянган га бөгөөд нийт газар нутгийн 7.96 хувийг эзэлдэг. Үүний 84.7 хувь буюу 10,558.9 мянган га нь шилмүүст болон навчит төрлийн, 15.2 хувь буюу 1,893.1 мянган га нь заган ой юм. Монгол оронд 2016 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа бөгөөд эрчимтэй цөлжиж байгаа бүс нутгийн экосистемийг сайжруулах чухал арга хэлбэр нь доройтсон ойг нөхөн сэргээх, говь цөлийн заган ойн санг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээ юм. 2019 оны байдлаар 643.1 мянган га шилмүүст болон навчит төрлийн, 855.8 мянган га заган, нийт 1,498.9 мянган га талбайд ойжуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 500 га ойжуулалт, 170 га ойн зурвасын ажил, байгалийн сэргэн ургалтад туслах ажил 1050 га, хомсдол доройтолд өртсөн ойд ойн цэвэрлэгээ хийж байгалийн сэргэн ургалтад туслах ажил 1047 га, ойн арчилгаа хийх замаар байгалийн сэргэн ургалтад туслах ажил 2000 га, сонгосон талбайд арчилгаа хийх замаар байгалийн сэргэн ургалтад туслах ажил 120 га талбайд тус тус гүйцэтгэж байна.





Зураг 14. Ойжуулалтын зардал ба ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь




Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ, ЗГҮАХ-ийн тайлан 2019

Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацаа (2017-2021)-ны төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээр улсын төсвөөс санхүүжих ойжуулалт зардал 2017-2018 онуудад шат дараатай нэмэгдэж 10.5 тэрбумд хүрсэн. Харин 2019 оноос эрс буурч сүүлийн 2 жилд, жилд дунджаар 6.0 тэрбум төгрөгийг ойжуулалт, ойн нөөцийн хомсдол, доройтлыг зогсоох, ойг нөхөн сэргээх, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэхэд зарцуулжээ. Ойжуулалт хийх, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх нь урт хугацаанд тогтвортой хөрөнгө оруулалт шаардаж 4-5 жилийн дараа үр дүн гарах цогц арга хэмжээ юм. Бодлогын бичиг баримтад тусгагдсан арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхэд нэмэлт хөрөнгийн эх үүсвэр шаардагдах тул төсвийн болон бусад эх үүсвэрийг татах зайлшгүй шаардлага үүсэж байна.



Зураг 15. Ойжуулалтын чиглэлээр 2020 онд зарцуулах төсвийн санал хянагдсан байдал /сая төг./



Эх сурвалж: БОАЖЯ

Ойжуулалтын чиглэлээр зарцуулж буй төсвийн ихэнх хувийг Хөрөнгийн зардал эзлэх бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтыг салбарын бодлогын баримт бичгүүдэд заасны дагуу ойт хээрийн бүсэд экологийн ач холбогдол бүхий газрыг шилмүүст модоор ойжуулах, ойн арчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд хэрэглэгдэх дэвшилтэт технологи бүхий гэрлэн урхи худалдан авах, ойт хээрийн бүсэд экологийн ач холбогдол бүхий газрыг шилмүүст модоор ойжуулах, ойн зурвас байгуулах, загаар ойн зурвас байгуулахад зарцуулж байна.

2020 оны төсвийн төслийг боловсруулах явцад Ойн судалгаа, хөгжлийн төвөөс нийт 12.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн оруулалтын шинжтэй арга хэмжээ хэрэгжүүлэх санал ирүүлсэн боловч, БОАЖЯ-ны зүгээс зарим арга хэмжээг бусдаар гүйцэтгүүлэхээр санал хүргүүлсэн боловч дэмжигдээгүй байна.


### Ус, цаг уур, орчны шинжилгээ

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой уур амьсгалын дулаарлын статистик мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргахын тулд ус, цаг уурын улсын сүлжээг өргөтгөх, техник, технологийн шинэчлэл хийх замаар судалгаа, шинжилгээ,

үнэлгээний ажлыг өргөжүүлэх чиглэлээр 2020 онд нийт 33.5 тэрбум төгрөгийг төсөвлөжээ. 2016 онд Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөс хамаарч ус, цаг уур, орчны шинжилгээний зардлыг 605 сая төгрөгөөр бууруулж, түүний дараах онуудад засгийн газрын чиглэл, салбарын бодлогын бичиг баримтууд, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан тус салбарт улсын төсвийн санхүүжилт жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Энэ салбарт нийт 1,900 орчим албан хаагч ажиллаж байна.

Цаг уурын шинжилгээ судалгаа, цаг агаарыг урьдчилан мэдээлэх, иргэний агаарын тээврийн цаг уурын мэдээлэл, үйлчилгээний чанарыг сайжруулж, нислэгийн аюулгүй байдлыг хангахад агаарын дээд давхаргын даралт, температур, чийг, салхины чиглэл, хурдны тухай мэдээлэл чухал үүрэг гүйцэтгэдэг. Аэрологийн станц байгуулах, Орчны чанарыг чанартай, түргэн шуурхай, олон үзүүлэлтээр тодорхойлох ажлыг хэвийн, тогтвортой гүйцэтгэхэд лабораторийн орчин үеийн шинжилгээний шаардлагатай багаж, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 2020 оны төсөвт холбогдох төсвийг нэмэгдүүлсэн байна.


Зураг 16. Ус цаг уур, орчны шинжилгээ /сая төг./



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ, ЗГҮАХ-ийн тайлан 2019

Цаг агаарын богино болон дунд хугацааны урьдчилсан мэдээний 2016-2019 оны 91.8-94.4% буюу өмнөх жилүүдээс дунджаар 2.0%-аар өссөн үзүүлэлттэй байна. Мөн ой хээрийн түймрийг унтраах, ган цөлжилтийг бууруулах зорилгоор 2016-2019 онд нийт 4,460 ширхэг пуужинг 1.8 тэрбум төгрөгөөр худалдан авч, 35-42 экспедиц үйл ажиллагаанд хэрэглэсэн байна. Энэ хугацаанд улсын хэмжээнд гарсан 180 орчим ой, хээрийн түймрийг унтраахад цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан байна.

Зураг 17. Цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрийн 2020 оны зардлын бүтэц /сая төг./



Эх сурвалж: БОАЖЯ

2020 оны урсгал төсвийн задаргаанаас харахад энэ салбарын төсвийн 67.3%-ийн ажиллагсдын цалин, хөлс, ажил олгогчоос төлөх даатгал шимтгэлд зарцуулжээ. Мөн тоног төхөөрөмжийн урсгал засвар, харьяа байгууллагуудын төсөвт урсгал шилжүүлэг байдлаар 5.3 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна.




### Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, уул уурхайн хайгуул, ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, Монгол орны байгалийн ургамлыг хамгаалах, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлын цогц менежментийг бий болгох, түүнийг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх, хаягдлыг дахин боловсруулах, түүнээс эрчим хүч үйлдвэрлэх замаар хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах гэсэн олон талт чиглэлд энэхүү төсвийн хөтөлбөрийг хэрэгжүүлж иржээ.

2012 оны 5 дугаар сард Байгаль орчныг хамгаалах тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу Байгаль орчны аудитын талаарх цогц арга хэмжээг авах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэхэд төсвийн урсгал зардал нэмэгдсэн байна. Мөн хүрээлэн буй орчны бодлогыг хэрэгжүүлэх олон талт үйл ажиллагааны төсөв 2018 онд 2 дахин нэмэгдэж дээр дурдсан чиглэлд өргөн хүрээг хамарч хэрэгжиж эхэлжээ. Мөн 2017 оны төсвийн жилээс эхлэн энэ салбарын суурь судалгаа, шинжилгээнд жил бүрийн төсөвт тодорхой хөрөнгө суулган боловсруулж түүнд үндэслэн хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийг хангаж байна.

Зураг 18. Хүрээлэн буй орчны чиглэлээр зарцуулсан төсөв /сая.төг/



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019

2018-2019 онд хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлэх зардлуудыг энэхүү төсвийн хөтөлбөрт хамруулан яамны бодлогын газрууд холбогдох арга хэмжээнд зарцуулдаг байсан бол 2020 оны төсвийн жилээс эхлэн зохих хөтөлбөрт хуваарилан зориулалтыг илүү нарийн тодорхойлж тусган гүйцэтгэлийг хэрэгжүүлж байна. Энэ жишгээр төсвийн хөтөлбөр хооронд зохицуулалтыг төлөвлөлтийн явцад хийж, зориулалтыг тодорхой болгох арга хэмжээг авч төсвийн дахин хуваарилах, хөтөлбөр, арга хэмжээ, зориулалтыг тодорхой болгох нь төсвийг төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх ажлыг ил тод, үнэн зөв, иж бүрэн, хариуцлагатай болгоно.




## Аялал жуулчлал

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, бүс нутаг бүрд аялал жуулчлалын хөгжлийг жигд цогцлоох, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн өндөр үр өгөөжтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн гол зорилтуудыг тодорхойлж “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 2019 оноос энэ салбарт улсын төсвийн санхүүжилтийг түлхүү хуваарилсан байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” батлагдаж төрөөс бүх салбарын зорилтыг тогтвортой хөгжилд чиглүүлж эхэлснээс буюу 2018 оноос Байгаль, орчин аялал, жуулчлалын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, өнөөг хүртэл үе шаттай өсөж байна. Мөн “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хийгдэж буй улсын төсвийн хөрөнгө оруулалт түлхүү хуваарилсан байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” батлагдаж төрөөс бүх салбарын зорилтыг тогтвортой хөгжилд чиглүүлж эхэлснээс буюу 2018 оноос Байгаль, орчин аялал, жуулчлалын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, өнөөг хүртэл үе шаттай өсөж байна. Мөн “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хийгдэж буй улсын төсвийн хөрөнгө оруулалт түлхүү хуваарилсан байна.

Зураг 19. Аялал жуулчлалын чиглэлээр зарцуулсан төсөв /сая.төг/ ба гадаад жуулчдын тоо



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ, ЗГҮАХ-ийн тайлан 2019

Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын тоо өсөхийн хэрээр нүүдлийн


соёл уламжлалыг шингээсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, жуулчдад үйлчлэх үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд нийт 6.3 тэрбум төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, 2020 онд нийт 8.3 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна. БОАЖЯ-наас 2020 оны төсөв боловсруулах явцад 10.3 тэрбум төгрөгийн арга хэмжээ хэрэгжүүлэх, суурь төсвийг нэмэгдүүлэх санал хүргүүлжээ.

### Хөрөнгийн зардал

2016-2019 оны хооронд байгаль орчин аялал, жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, төв, орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай нийт 25.0 орчим тэрбум төгрөгийн өртөгтэй 33 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн байна. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний цогцолборуудыг барьж байгуулах, томоохон төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 11 төсөл, арга хэмжээнд 13.2 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” батлагдаж төрөөс бүх салбарын зорилтыг тогтвортой хөгжилд чиглүүлж эхэлснээс буюу 2018 оноос Байгаль, орчин аялал, жуулчлалын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, өнөөг хүртэл үе шаттай өсөж байна. Мөн “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хүрээнд аялал жуулчлалын салбарт хийгдэж буй улсын төсвийн хөрөнгө оруулалт түлхүү хуваарилсан байна.

Зураг 20. 2015-2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт оруулсан Улсын төсвийн хөрөнгө оруулалт /сая.төг/



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ

Сүүлийн 5 жилд Усны нөөц, гол мөрний менежментийн чиглэлээр харьцангуй их төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. 2015-2017 оны хооронд жил дараалан Хот, суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгааг Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймгуудыг хамруулан шат дараатай боловсруулж 2018 оны улсын хэмжээнд хот, суурин газрын усны хангамжийн эх үүсвэрийг тогтоох, хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэхэд нийт 1.1 тэрбум төгрөгийг төсвөөс зарцуулжээ.

БОАЖЯ-ны зүгээс урсцын хувьд доройтолд орсон, ширгэх аюул тулгарсан томоохон гол, нууруудыг чиглэсэн томоохон ажлуудыг зохион байгуулж, Ганга, Өгийнуур, Тэрхийн цагаан нуур, Улз гол, Аварга нуурын зүүн бүрдийн бохирдлыг бууруулах, ширгэлтээс хамгаалах, урсцыг нэмэгдүүлэх ажлуудыг хийжээ. Гадаргын усыг хуримтлуулах, мал ундаалах, ургамлын хөгжилтийг дэмжих зорилгоор Увс аймгийн Хяргас, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдад 4.4 тэрбум төгрөгийг мөн улсын төсвөөс санхүүжүүлжээ. Мөн Ховд голын усны голдирол өөрчлөх, суваг шуудуу сэргээх, шинээр татах ажлыг зохион байгуулсан байна.

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт усны нөөцийн судалгааг боловсруулах, усны нөөц, мужлалын хувьд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохоор Усны техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр хийхээр төлөвлөөд байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр 2015-2017 онуудад орон нутгийн байгаль орчны газрын конторын барилга барих зэрэг барилга, байгууламж барихад төсвөөс хөрөнгө оруулж байсан бол 2019 оноос хүрээлэн буй орчны чиглэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг чиглүүлж Чингэлтэй хайрханы тусгай хамгаалалттай газрыг ойжуулах, нөхөн сэргээлт, тохижилтыг хийх, Баянзүрх дүүргийн 6, 15, 18, 25, 26 дугаар хороодын нутаг дэвсгэрт Ногоон байгууламж барих ажлуудыг улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлж зорилтот чиглэлд зарцуулах хандлагатай байна.




Зураг 21. 2015-2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт оруулсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын бүтэц /сая.төг/



Эх сурвалж: СЯ Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2019, БОАЖЯ

“Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хүрээнд 2018 оноос аялал жуулчлалыг нүүдэлчдийн ёс заншил, уламжлал, түүх соёлын давтагдашгүй үнэт өв, унаган төрхөө харьцангуй сайн хадгалж үлдсэн үзэсгэлэнт газар нутаг, Чингис хаан, түүний өв залгамжлагчдын үлдээсэн түүхийн өвийг хамгаалахад, бүсчлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг улсын төсвийн хөрөнгөөр хийж байна.



2018 оноос эхлэн “Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн” цогцолбор, “Хүлэгбаатар Боорчи-Андлалын Өргөө” цогцолбор, “Шихихутаг нууц товчоо” түүхэн аялал жуулчлалын цогцолбор, Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны хөгжлийн “Соёмбо” цогцолбор, Хатдын өргөө, “Монголын нууц товчоо” түүхэн аялал жуулчлалын цогцолборууд барих ажлууд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байна. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, Архангай аймгийн Булган, Ихтамир, Өндөр-Улаан, Цахир, Тариат, Хангай, Чулуут, Жаргалант зэрэг суманд аялал жуулчлалын замын тэмдэглэгээ, самбар хийх, Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн цогцолборын барилгын интерьер, дотоод уран сийлбэр шинэчлэл, гадна цахилгаан хангамж, Монгол Улсын “Төв цэг”-ийн засвар, тохижилтын ажлуудыг БОАЖЯ-ны сайдын багцад тусгаж хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Цаг уур, орчны шинжилгээний дэд бүтцийг сайжруулах, цаг агаарын мэдээ, таамаглалыг бодитой боловсруулахад дэмжлэг үзүүлэх, цаг уурын станц, байгууламжуудыг өргөтгөх хүрээнд Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байрыг Улаанбаатар хотод, цаг уурын өртөөний барилгуудыг Ховд, Увс, Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудын сумдад байгуулж байна.



### Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт дипломат харилцаатай улс орнууд, хөгжлийн түнш Олон улсын байгууллагууд болон Олон улсын гэрээ, конвенцын дагуу хамтран ажилладаг байгууллагуудаас хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн төслүүд хэрэгжсээр байна.

Одоогоор Монгол Улс НҮБ-ын суурь буюу Риогийн 3 Конвенц болох Биологийн төрөл зүйл, Цөлжилттэй тэмцэх, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенц, Озоны давхаргыг хамгаалах тухай, Химийн 3 конвенц болох Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмийн конвенц, Аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц, Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж

зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц болон Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах Боннын конвенц, Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцод нэгдсэн орж гишүүн улс орон, олон улсын байгууллагуудтай Хоёр талт болон Олон талт хамтын ажиллагааг дэмжин ажиллаж байна.

БОАЖА-ны веб хуудсанд мэдээлснээр 1992 оноос эхлэн Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн чиглэлээр 14, Ойн бодлого, менежментийн чиглэлээр 6, Усны бодлого, менежментийн чиглэлээр 4, Цөлжилтийн эсрэг 3, Химийн бодисын хэрэглээ, аюулгүй байдлын чиглэлээр 5 цогц төслийг гадаадын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн байна.

Одоогоор хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдээс ХБНГУ-ын Засгийн газар Сэргээн босголтын зээлийн банк болон Монгол Улсын Засгийн газар хамтран санхүүжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл нийт тусгай хамгаалалттай газрын захиргаад, сав газрын захиргаадад техник туслалцаа хүргэж өргөн хүрээтэй хэрэгжиж байна.



Хүснэгт 2. БОАЖ-ын салбарт хэрэгжиж буй Гадаадын зээл, тусламжийн төслүүд

Д/д	Төслийн нэр	Санхүүжүүлэгч байгууллага	Хэрэгжих хугацаа	Нийт санхүүжилт
<b>Байгалийн нөөцийн тогтвортой менежмент</b>				
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	ХБНГУ-ын Засгийн газар, Сэргээн босголтын зээлийн банк KFW	2015.05-2020.05	15.3 сая евро. Үүнээс: ХБНГУ-ын Засгийн газар 11.5 сая евро Монгол Улсын Засгийн газар 3.8 сая евро
2	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах	АХБ-Ядуурлыг бууруулах Японы сан	2017.01-2020.12	2.8 сая ам.доллар
3	Монгол Улсад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх (SESMIM)	Канадын Засгийн газар	2016.04-2020.4	
4	Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх тогтвортой аялал жуулчлалыг дэмжих MON 48216	АХБ-Ядуурлыг бууруулах Японы сан	2016.03-2019.12	Ядуурлыг бууруулах Японы сан 3.0 сая, МУЗГ 180.0 мянган ам доллар
<b>Ойн бодлого, менежмент</b>				
5	Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төсөл	БНСУ-ын Ойн алба	2016.07-2021.07	9 сая ам.доллар
<b>Ногоон хөгжил, ногоон эдийн засаг</b>				
6	“Хог хаягдал ба Уур амьсгалын өөрчлөлт” бүсийн төсөл	ХБНГУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж	2017.07-2021.07	2.5 сая евро
<b>Био аюулгүй байдлыг хангах, химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалт</b>				
7	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ил шаталтад БАТ,БЭП нэвтрүүлэх бүсийн төсөл	Даян дэлхийн байгаль орчин сан	2016-2020	1.5 сая ам.доллар
8	Төв Азийн орнуудад био аюулгүй байдал, био аюулгүй ажиллагааг хангах Р53 бүсийн төсөл	Европын холбоо	2017-2020	5 сая ам.доллар

Гадаад зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилт нь төслийн бэлтгэл ажил, худалдан авалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, төрөл бүрийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, хөгжлийн түншүүдийн дотоод процедур,

хоёр талын төрийн байгууллагын дотоод журам, улирлын уялдаа болон бусад хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байдаг. Санхүүжилтийг уян хатан, шуурхай шийдвэрлэх, төсвийг үр ашигтай ашиглах зорилгоор 2019 оны төсвийн жилээс гадаад зээл, тусламжийн санхүүжилт болон гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын хариуцах санхүүжилтийн зардлыг нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад буюу Сангийн сайдын багцад суулгасан. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн санхүүгийн бүртгэл мөн адил Сангийн сайдын багцад шилжсэн.

Энэ салбарт 2019 оны төсвийн жилд 13.8 тэрбум төгрөг, 2020 оны төсвийн жилд 30.9 тэрбум төгрөгийн гадаад зээл, тусламжийн төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг зохион байгуулсан.

Цаашид байгаль орчин, аялал жуулчлалын салбарт орж буй гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөх, салбарын бодлого болон улс, орон нутгийн төсвөөс зарцуулж буй хөрөнгөтэй харилцан уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

*Хүснэгт 3. 2020 оны төсөвт БОАЖ-ын сайдын багцад тусгагдсан Гадаадын зээл, тусламжийн төслүүд /сая төгрөг/*

Төсөл	2019	2020 бат.
Мазаалай баавгайн амьдрах орчныг сайжруулах төсөл	1,213.5	441.7
Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	6,220.0	7,000.0
Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II шат	4,500.0	7,040.4
Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох III шат		124.0
Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх тогтвортой аялал жуулчлалыг дэмжих MON-48216	1,941.8	625.7
Мазаалай баавгайн амьдрах орчныг сайжруулах төсөл MTX		84.1
Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл		4,374.1
Байгаль орчны төв лабораторийн чадавхыг бэхжүүлэх төсөл		11,226.1

## БОАЖ-ын салбарын бодлогын хэрэгжилт Орон нутгийн түвшинд хэрэгжиж буй байдал

Тус салбарын Улсын төсвөөс санхүүждэг, БОАЖА-ны харьяа босоо удирдлагатай агентлаг, байгууллагуудад БОАЖА-ны газар, хэлтсүүд чиг үүргийн дагуу бодлого, удирдлагаар ханган ажиллаж үр дүнгийн гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж жил бүр дүгнэдэг. Харин аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад бодлого, зөвлөмж өгч тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай Хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний биелэлт 2017 онд дунджаар 81.9 хувь буюу "В" үнэлгээтэй, 2018 онд 80.9 хувь буюу "В" үнэлгээтэй хэрэгжсэн байна.


Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Хэнтий, Булган, Архангай, Ховд, Дорноговь, Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон зэрэг аймаг ТХЗ, 2016 оны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд суурилан өөрсдийн ногоон хөгжлийн 2016-2024 оны стратегийг боловсруулан баталсан байна. Эдгээр стратегид хот төлөвлөлт, ногоон барилга байгууламж, тээвэр, ойжуулах үйл ажиллагаа, тогтвортой бүтээгдэхүүн, хог хаягдлын менежмент, тогтвортой аялал жуулчлал, тогтвортой ХАА, ногоон хөрөнгө оруулалт, санхүүжилт, ногоон ажлын байр зэрэг аймгийн онцлог зорилгуудыг тусгажээ.



Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ногоон хөгжлийн стратегийг батлахаас гадна түүнд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн төсөлд тусган ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх нь хамгийн том сорилт болж байна. Сүүлийн 3 жилийн тоон мэдээллээс харахад Булган аймаг байгаль орчин, аялал жуулчлалын зориулалтаар нийт 11.0 тэрбум төгрөгийг буюу дунджаар жилийн төсвийн 6.64 хувийг Орон нутгийн төсвөөс зарцуулсан байхад уул уурхайн томоохон үйлдвэрлэл бүхий Өмнөговь аймаг 3 жилд нийт 1.0 тэрбум төгрөгийг буюу жилийн төсвийн 0.28 хувийг дээрх зориулалтаар зарцуулж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Байгаль орны чиглэлээр орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг чухалчлах бус Орон нутгийн төсөвт эзлэх хувийг тогтвортой нэмэгдүүлж, жилийн төсөв боловсруулах, батлуулах процесст оруулж уламжлал болгох нь нэн чухал байна.

Зураг 22. Аймаг, нийслэлийн сүүлийн 3 жилд Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр Орон нутгийн төсвөөс зарцуулсан хэмжээ, аймаг, нийслэлийн төсөвт эзлэх хувь



Эх сурвалж: СЯ,Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2016-2019

Байгаль орчны үйл ажиллагааны зардал болон холбогдох үндэсний хөтөлбөрүүдийн санхүүжилт нь үндсэндээ улсын төсвийн хуваарилалт болон гадаадын зээл, буцалтгүй тусламжаас хамаарч байна. Байгаль орчин, уур амьсгалын сангийн байгаль орчинтой холбоотой үндэсний хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан хуваарилсан хөрөнгө бага хэвээр байна. Орон

нутгийн удирдлага байгаль орчны зардлыг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс гаргах ёстой боловч Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт хангалттай хэмжээнд хүрэхгүй байгаа нь нийтлэг ажиглагдаж байна.

Хүснэгт 4. 2016-2018 онд Орон нутгийн төсвөөс Байгаль орчин хамгааллын чиглэлээр Орон Нутгийн төсвөөс зарцуулсан хэмжээ /сая төгрөг/

	2016		2017		2018	
Булган	3,732.9	7.2%	3,309.1	6.2%	3,971.8	6.5%
Улаанбаатар	25,456.2	2.4%	29,672.2	2.7%	34,050.3	2.6%
Говьсүмбэр	284.0	1.9%	395.2	2.7%	375.4	2.4%
Хөвсгөл	1,535.4	1.8%	2,232.7	2.4%	1,686.3	1.6%
Сэлэнгэ	1,215.9	1.7%	1,605.1	2.1%	1,585.1	1.9%
Сүхбаатар	906.3	1.7%	1,062.0	2.1%	953.0	1.7%
Төв	1,062.9	1.5%	1,517.2	2.0%	1,674.5	2.0%
Архангай	1,122.2	1.8%	1,240.5	1.9%	1,123.7	1.5%
Дархан-Уул	920.2	1.6%	1,085.6	1.8%	1,047.4	1.4%
Хэнтий	877.1	1.5%	821.5	1.4%	1,074.1	1.6%
Дорнод	556.3	1.0%	816.7	1.5%	956.4	1.5%
Баянхонгор	520.1	0.8%	1,088.6	1.6%	1,073.5	1.4%
Завхан	648.5	1.1%	765.3	1.2%	843.0	1.2%
Увс	701.9	1.1%	785.0	1.2%	842.7	1.1%
Говь-Алтай	495.2	0.9%	570.8	1.1%	527.7	0.9%
Ховд	411.4	0.7%	562.2	0.9%	554.6	0.8%
Дундговь	125.3	0.3%	352.1	0.9%	398.1	0.9%
Баян-Өлгий	465.5	0.7%	559.9	0.8%	523.3	0.6%
Өвөрхангай	489.8	0.7%	466.4	0.6%	478.5	0.6%
Дорноговь	229.0	0.5%	331.3	0.6%	387.3	0.6%
Орхон	617.3	0.7%	252.1	0.3%	199.1	0.2%
Өмнөговь	363.9	0.3%	335.9	0.3%	377.0	0.2%

Аймаг, нийслэлийн засаг дарга нь тухайн газар нутагтаа байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, энэ чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардагдах төсвийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, захиран зарцуулдаг. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуулийн дагуу Орон нутгийн төсөвт төвлөрсөн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд тус хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулах үүрэгтэй.



Зураг 23. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого, зарцуулалт



Эх сурвалж: БОАЖЯ, Байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн хүрээнд төвлөрсөн орлого нь орон нутагт байгаль хамгаалах, нөхөн сэргээх, нуур, булаг, шанд хамгаалах, аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох хөрөнгийн гол эх үүсвэр тул тухайн хуулийн хэрэгжилтийг хангаж хуулийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулах нь бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга нарын гол анхаарах асуудал болж байна.

2016-2019 оны тоон мэдээллээс харахад “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн хэрэгжилт жил ирэх бүр нэмэгдэж байгаа хэдий ч тус хуулийн хүрээнд төвлөрч буй орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулж буй хөрөнгийн үр дүнтэй байдал, байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргаж буй улс орны хэмжээний бодлоготой хэрхэн уялдаж буй талаарх үйл ажиллагааны хяналтын механизмыг дахин нягтлах шаардлагатай болж байна.

БОАЖ-ын сайдын аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2017, 2018 оны биелэлтийн тайлангаас (БОАЖЯ, www.mnpe.mn) үзэхэд нуур, булаг шандыг хамгаалах, хашаалуулах, ховор ашигт ургамлын нөөцийн судалгааны ажлын хэрэгжилт, нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, өвс хужир, мараа тавих, хөв цөөрөм байгуулах, биологийн төрөл зүйлийн судалгаа хийх, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.



## ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

### 1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын чиглэлээр үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдаж буй зорилтуудын эдийн засгийн тооцоог тооцоолж тусгах.

Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2016 онд баталж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2016-2020 болон 2021-2030 онуудад хэрэгжүүлэх өргөн хүрээг хамарсан стратегийн 6 зорилго, 51 тусгай зорилт, 255 арга хэмжээг тодорхойлжээ. “Алсын хараа 2050”, Ногоон хөгжлийн бодлого, “Ус” үндэсний хөтөлбөр, Цаг уур, орчны шинжилгээний үндэсний хөтөлбөр, Аймаг, нийслэлийн Ногоон хөгжлийн бодлого зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх өртөг зардал болон санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаагүй байна.

Түүнчлэн, тэдгээр зорилтыг жил жилийн болон дунд хугацааны улсын төсөв боловсруулах үйл явцтай хэрхэн уялдуулах нь тодорхой бус байна. Үүнээс гадна ихэнх нь хэрэгжиж эхлээд явж байгаа байгаль орчны холбогдол бүхий үндэсний хэмжээний усны үндэсний хөтөлбөр; Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр болон Биологийн олон янз байдлыг хамгаалах хөтөлбөр зэрэг 17 хөтөлбөр байна.

Эдгээр хөтөлбөрүүдийн хувьд ч гэсэн дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх өртөг зардлын тооцоо байхгүй байна. Улмаар өртөг зардлын тооцоо хийгдээгүй тул ирэх жилүүдэд БОАЖС-ын багцад хэрхэн нөлөөлөх талаар төсөөлөл боловсруулахад хүндрэл үүсэж байна. Хэрэв бодлогын зорилтуудыг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхэд эдийн засгийн тооцоолол, өртөг зардлын төсөөлөл гаргах нь цаашид төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсөвт тусгахад дөхөм болно.

### 2. Төсөв боловсруулах, гүйцэтгэл зохион байгуулах бүх шатанд Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Төсвийн зарчмуудыг бүрэн мөрдөх.

Салбарын санхүү, төсвийн бүртгэлийг сайжруулах, төсвийг иж бүрэн байдлыг хангах, төлөвлөх, тайлагнах бүх шатанд төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод,

хариуцлагатай байдлыг хангасан байх шаардлагатай. Дунд хугацааны болон жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, хянах, төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах үйл явцад хуулиар тавигдах ерөнхий шаардлагад нийцсэн байх нь цаашид нотолгоо-үр дүнд чиглэсэн төсөвлөлт рүү шилжих урьдач нөхцөл болно.

### 3. Байгаль орчны үйл ажиллагааны зардал болон холбогдох үндэсний хөтөлбөрүүдийн санхүүжилт нь үндсэндээ улсын төсөв болон гадаадын зээл, буцалтгүй тусламжаас хамаарч байна.

Сүүлийн 6 жилийн салбарын төсвийн статистик үзүүлэлтээс харахад энэ салбарт цаашид төсвийн бусад эх үүсвэрийг бүрэн дайчлах, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг байгаль орчин, аялал жуулчлалын салбарт зохистой хэмжээнд хуулийн хүрээнд нэвтрүүлэх шаардлагатай байна. БОАЖА-ны зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, төсвийн хувьд бие даасан аж ахуйн тооцоот байгууллагуудыг байгуулж, төсөвт ирэх дарамтыг бууруулах боломжийг эрэлхийлэх

### 4. Гадаадын зээл, тусламжийн арга хэмжээний төлөвлөлтөд БОАЖА-ны оролцоо, төлөвлөх, тайлагнах оролцоог нэмэгдүүлэх.

Ингэснээр энэ салбарт хэрэгжүүлж буй бодлогын нэгдмэл байдлыг хангаж, бодлогын зорилтуудыг хангахад хөрөнгийн бусад эх үүсвэртэй уялдуулан хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, энэ салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын шинжтэй үйл ажиллагааны бодлогын нэгдмэл байдлыг хангах нь зүйтэй. Мөн гадаадын тусламжаар энэ салбарт орж ирж буй хөрөнгийн бүртгэлжилтийг сайжруулах, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд тусгах шаардлагатай.

### 5. Салбараас улсын болон орон нутгийн төсөвт төвлөрөх төсөвт байгууллагын өөрийн орлогыг бүрэн дайчлах эрхзүйн орчин бүрдүүлэх.

Эдийн засгийн өсөлт, инфляц, төгрөг ханшийн өөрчлөлт зэргийг харгалзан тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үечилгээний төлбөрийг нэмэгдүүлэх, байгаль орчны салбарын байгууллагын үйлчилгээний хураамж, нэвтрэх цэгийн хураамжийн хэмжээг дахин авч үзэх, харьцуулсан судалгаа хийх замаар, улмаар холбогдох хууль, журмыг шинэчлэн боловсруулах замаар салбар байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөх хэрэгцээ байна.



### 6. Шинээр хэрэгжиж буй, орлого бүрдүүлэх зарим хуулийн хэрэгжилтэд анхаарч, хуулийг дагаж гарсан журмыг нийтэд сурталчлах.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих, ус бохирдуулсны төлбөрийг тооцоолох чиглэлээр БОАЖ-ын сайдын баталсан журмуудыг ус хэрэглэгч, ашиглагч нарт сурталчлах, мөн энэхүү хуулийн хэрэгжилтийн хүрээнд төвлөрсөн орлогоос усны хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зарцуулалтын хяналтын механизмыг бүрэн хэрэгжүүлэх нь зүйтэй.

### 7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах.

Энэхүү хууль нь орон нутагт байгаль орчин, аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль хамгаалал, хүрээлэн буй орчны хамгааллыг гүйцэтгэх орлогын гол эх үүсвэр болж байгаа тул хуулийн хэрэгжилтийг хангах талаар үе шаттай арга хэмжээ авах, аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдах албан тушаалтнууд, төсвийн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, холбогдох сургалт зохион байгуулах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна.

### 8. Алс хязгаар нутагт ажиллаж буй бусад төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоог нягтруулах.

Ялангуяа хил орчмын тусгай хамгаалалттай газар нутаг, сав газарт хийгдэх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үйл ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллагууд, Хил хамгаалах ерөнхий газрын анги, нэгтгэлүүдтэй хамтран зохион байгуулах, урсгал зардлыг хэмнэх зорилгоор техник хэрэгсэл, унаа, уналгыг хамтран эзэмших чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай байна.

### 9. Норматив зардлыг тооцох нэгдсэн аргачлалыг сайжруулах.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг хангах, усны хамгааллын үйл ажиллагаа нь тогтмол хяналт тавьж, орчны бүсийн иргэдийг сурган дайчилж, хяналт-мониторингийг тогтмол хуваариар урт

хугацаанд хийж байж үр дүнгээ өгдөг онцлогтой. Иймд эргүүл хяналт хийх, тандалт судалгаа, орчны бүсийн судалгаа боловсруулахад гарах томиллолт, шатахуун, тоног төхөөрөмж, хэрэгслийн зардлыг газарзүйн онцлог байдал, амьтан, ургамлын тархцад суурилан тооцох нэгдсэн аргачлалыг сайжруулах шаардлагатай байна. Ингэснээр харьяа байгууллагуудын төсвийн төлөвлөлтийг хийх, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа тодорхой, ил тод, бодитой болно.

#### **10. БОАЖС-ын багцад төсвийн дахин хуваарилалт хийх, бодлогын арга хэмжээг эрэмбэлэх замаар хөтөлбөр-үр дүнд суурилсан төсөвлөлт рүү үе шаттай шилжих.**

Салбарын онцлогоос хамаарч бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг 1-2 төсвийн жилд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй юм. Иймд бодлогын арга хэмжээг эрэмбэлэх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж төсвийн хөтөлбөр хооронд зохицуулалтыг төлөвлөлтийн явцад хийж, бодлогын зорилтод хүрэх үе шатыг тодорхой болгох арга хэмжээг авч төсвийн дахин хуваарилалт хийх шаардлагатай байна. ТЭЗ-д хуулиар олгогдсон эрхийн хүрээнд салбарын төсвийг төлөвлөх, хэлэлцэх, хэрэгжүүлэх шатанд хөтөлбөр, арга хэмжээ, зориулалтыг тодорхой болгосноор төсвийн хэрэгжилтийг ил тод, үнэн зөв, иж бүрэн, хариуцлагатай зохион байгуулах боломжтой болно.

#### **11. Улсын төсвөөс санхүүждэг сав газрын захиргаад, тусгай хамгаалалттай газрын захиргаад төсвийн дутагдалтай байдал нийтлэг байна.**

Алс хязгаарлагдмал нутагт үйл ажиллагаа явуулдаг зарим захиргаад газарзүйн онцлог, ой хээрийн түймэрт өртөх магадлал болон бусад гарч болох эрсдэлийг тооцон төсвийн хуваарилалтыг оновчтой хийх бодит шаардлага байна. Эдгээр байгууллагууд үйлчилгээний хураамж, дүгнэлт гаргасны төлбөр хураамжийг үлдээж байгууллагын үйл ажиллагааны зардалд ашиглах боломжгүй байна.



#### **12. Төсвийг зориулалтын дагуу зарцуулах**

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар салбарын байгууллагуудад тогтмол сурталчлах, Байгаль орчин болон байгаль хамгаалахад хуваарилж байгаа хөрөнгийг орон нутгийн засаг захиргаа үр дүнтэй ашиглахад арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, БОАЖ-ын сайд болон аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулж буй үр дүнгийн гэрээний загварыг салбарын онцлогт нийцүүлэн шинэчлэх, үнэлэх үйл ажиллагааг ил тод нээлттэй хийх шаардлагатай.

#### **13. Сав газрын захиргаад, Тусгай хамгаалалтын захиргаад, Орон нутгийн БОАЖ газрын чадавхыг бэхжүүлэх.**

Тухайлбал, Монгол Улсын хэмжээнд 29 усны сав газрын 21 сав газрын захиргаад чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай туршлага дутагдалтай байна. Иймд сав газрын захиргааны ажиллагсдын чадавхыг дээшлүүлэх, сургах, мэргэжил дээшлүүлэх нь тэдгээрийн хариуцсан үүргээ хэрэгжүүлэх болон Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн Зорилго 6.5 –ийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ



- Hege, E., Brimont, L. (2018). Integrating SDGs into national budgetary processes. Studies N°05/18, IDDRI, Paris, France
- Mulholland, E., Berger, G. (2019). "Budgeting for the SDGs in Europe: Experiences, Challenges and Needs", ESDN Quarterly Report 52, April 2019, ESDN Office, Vienna.
- OECD (2019), Governance as an SDG Accelerator: Country Experiences and Tools, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/0666b085-en>
- UNECE (2018), Environmental Performance Review of Mongolia, November 2018, No.49, ECE/CEP/182, Geneva
- Chiwara, Richard M., Aldar, D., and Sergelen, B. (2015). Evaluation of the United Nations Development Assistance Framework for Mongolia, UNDAF 2012–2016, Fact Sheet, Asian Development Bank ADB and Mongolia. April 2015.
- Flores, M., Gonchigsumlaa, G., and Surenjav, K. (2015). An Economic Valuation of Contribution of Ecosystem Services of the Network of Protected Areas to the Economy of Mongolia.
- Shiilegmaa, A. et al. (2015). Mongolia – Public financial management performance report. Washington, D.C.: World Bank Group.
- Nganou, J., D. Batsuuri, S. Nyanzi, and A. Shiilegmaa. 2018. Mongolia Economic Update: Fiscal Space for Growth—The Role of Public Investment Spending Efficiency: Main Report (English). Mongolia Economic Update. Washington, D.C. : World Bank. <http://documents.worldbank.org/curated/en/648031532963732140/main-report>
- World Bank, 2018c: Mongolia Economic Update: Fiscal Space for Growth: The Role of Public Investment Spending Efficiency. Washington, DC.
- International Monetary Fund. Staff report for the third review under the Extended Fund Facility. Washington, D.C., 2018. [www.imf.org/~media/Files/Publications/CR/2018/cr1898.ashx](http://www.imf.org/~media/Files/Publications/CR/2018/cr1898.ashx)
- БОАЖЯ (2020), Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2016-2019 оны онцлох ажлууд
- БОАЖЯ, Монгол орны Байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014 он, 2015-2016 он, 2017-2018 он
- Ариунаа Л, Монгол төрийн эдийн засгийн бодлого /сорил, сургамж, асуудал/ 1911-2018
- Burcher, C., and F. Bértoa. 2018. Political Finance in Mongolia: Assessment and Recommendations. Stockholm: International Institute for Democracy and Electoral Assistance.
- Flores, M., Gonchigsumlaa, G., and Surenjav, K. (2015). An Economic Valuation of Contribution of Ecosystem Services of the Network of Protected Areas to the Economy of Mongolia. Available from: [https://www.researchgate.net/publication/291693931\\_An\\_Economic\\_Valuation\\_of\\_Contribution\\_of\\_Ecosystem\\_Services\\_of\\_the\\_Network\\_of\\_Protected\\_Areas\\_to\\_the\\_Economy\\_of\\_Mongolia](https://www.researchgate.net/publication/291693931_An_Economic_Valuation_of_Contribution_of_Ecosystem_Services_of_the_Network_of_Protected_Areas_to_the_Economy_of_Mongolia)
- Green Climate Fund (2017). Mongolia Country Programme Brief.

International Monetary Fund (2010). Mongolia – The fiscal regime for mining – A way forward. June 2010. Available from: <http://www.eisourcebook.org/cms/January%202016/Mongolia%20Fiscal%20Regime%20for%20Mining.%20IMF.pdf>

International Monetary Fund, Mongolia 2015 Article IV Consultation – Country Report 15/109 April 2015.

International Monetary Fund, 2017 Article IV Consultation Mongolia – Country Report No. 17/140 May 2017.

International Environment Technology Centre UNEP (2017). Mongolia National Waste Management Improvement Strategy and Action Plan 2017–2030. July 2017.

United Nations, United Nations Development Assistance Framework (2016). Mongolia, 2017 – 2021.

Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дүрэм, заавар, журам 2019 З.Батжаргал  
НЗДТГ-ын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс, Санхүү, төсвийн заавар журмын  
эмхэтгэл Төсвийн ерөнхий менежер, бүртгэл санхүү, хүний нөөцийн ажилтнуудын албан  
ажлын хэрэгцээнд / Эмх. Ц.Долоонжин, Б. Норжинлхам

Монгол Улсын 2015-2021 оны төсвийн тухай хууль дагалдах хууль тогтоомж, түүний  
танилцуулга, <http://www.legalinfo.mn>

СЯ, Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, түүний танилцуулга (2015-2019)

ҮСХ. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл (2015-2019)



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр  
Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд  
дэмжлэг үзүүлэх төсөл  
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг  
Нэгдсэн Үндэстний Гудамж-14  
Утас: 976-11-327585, Факс: 976-11-326221  
И-мэйл: [registry.mn@undp.org](mailto:registry.mn@undp.org)  
[www.mn.undp.org](http://www.mn.undp.org)